



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн нийтийн их цэвэрлэгээний өдөр тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2013 оныг “Нийгмийн хариуцлагын жил” болгосонтой холбогдуулан Баянгол дүүргийн хэмжээнд иргэдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж талбайд үүссэн хог хаягдал, цас мөс, хальтиргаа гулгаа, нийтийн өмчийн эд хөрөнгийг тогтмол цэвэрлэх Баянгол дүүргийн нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүрийн Бямба гаригт 11.00-14.00 цагийн хооронд тогтмол зохион байгуулсугай.

2. Нийтийн их цэвэрлэгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, цэвэрлэгээний ажлын удирдамжийг гуравдугаар, шаардагдах хөрөнгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Нийтийн их цэвэрлэгээний ажлын удирдамжийн дагуу мөрдлөг болгон орон сууц, гэр хорооллын гудамж талбай, гуу жалга, далан суваг болон нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч тодорхой үр дүн гаргаж ажиллахыг ажлын хэсэг, хороодын Засаг дарга нарт, төлөвлөгөөнд заасан чиг үүргийн дагуу үр дүнтэй, бодитой ажил зохион байгуулж оролцохыг нийт төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, сууц өмчлөгчдийн холбоод, иргэдэд үүрэг болгосугай.

4. Цэвэрлэгээний ажлын явц, үр дүнд тогтмол хяналт тавьж долоо хоног бүр хороо тус бүрээр ерөнхий ажлын төлөвлөгөө гарган чанартай зохион байгуулсан хороодыг урамшуулах, хангалтгүй ажилласан хороодын Засаг даргын ажлыг үнэлж дүгнэн ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Г.Энхболд/-д даалгасугай.

5. Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулахад шаардлагатай 4961700 /Дөрвөн сая есөн зуун жаран нэгэн мянга долоон зуу/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Тамгын газар /М.Бадрах/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ОРОСОО

